



Гэрээр Олгох Боловсрол төв

Б.Батаа

Гэрээр Суралцахуй



Энэ товхимолд Танд:

Гэрээр Суралцахуй гэж юу вэ?

Яагаад гэрээр суралцах ёстой вэ?

Гэрээр суралцах нь хэнд ямар ашиг тустай вэ?

Гэрээр суралцах ямар арга замууд байна вэ?

зэрэг олон асуултанд хариулт авахад тусална.

Home based education

Зохиогчийн эрх “Гэрээр Олгох Боловсрол” төвд хадгалагдана.
Бүтээлийг бүтнээр болон хэсэгчлэн нийтлэх тохиолдолд “Гэрээр
Олгох Боловсрол” төв, зохиогчийн нэрийг дурдана.

Зохиогч: Б.Батаа

Хэвлэлийн эхийг бэлтгэсэн: Б.Батаа, Ч. Оюунтүлхүүр

Цаасны хэмжээ - А5

Хэвлэлийн хуудас: 2.12 х.х

Улаанбаатар, 2006 он



Эрхэм хүндэт эцэг эхчүүд, багш, сурагчид аа!

Энэ зуунд боловсрол л хамгийн үнэ цэнэтэй хөрөнгө гэгдэх боллоо. Таны хүүхдэд хэрэгтэй өв бол ямар нэг хөдөлшгүй хөрөнгө бус, цагийг нь олж эзэмшүүлсэн боловсрол, сурах чадвар юм. Сургуульд сайн, муу сурах, цалин их, бага байх нь хүний амьдралд чухал бус, харин хүн ухаалаг, боловсорч амьдрах нь чухал. Сурах, боловсрох нь гагцхүү амьдралд бэлтгэх ажил үйл билээ.

Хүү, охин маань үүнийг сургуульд сурч байгаа шүү дээ гэж найдаж болохгүй! Бидний хүүхдүүдийн амьдрах ертөнц манай одоогийн сургуулиас 4 дахин хурдацтай өөрчлөгдөж байхад, ихэнх сурагчид аль эрт эрин үе нь өнгөрсөн сургуулийн анги танхимд уйтгарлан сууж байна. Үйлдвэрлэлийн эрин үеэ өнгөрөөсөн шиг сургуулийн хуучин хэв маяг халаагаа өгөх цаг болжээ. Анги танхимын сургалтаас гадна гэрийн, зайн, он-лайн, виртуал сургалтууд хүчээ авч эхэллээ.

Хүн бүхний оюун ухаан давтагдашгүй өөр. Оюун судлаачид оюун тархины үндсэн 8 хэв шинжийг тодорхойлоод байна. Хэний ч оюун сурч боловсроход зориулагдсан туйлын үржил шимт хөрс байдаг. Уг оюун эрүүл хүнийх л бол, хэнийх ч бай сурч боловсрох хязгааргүй их боломжтой байдаг. Зөв зүйтэй тогтолцоо байх аваас, таарсан тохирсон боловсролын үрийг суулгаж, бордож, арчилж, арвин их ургацыг авч чадахсан. Хүн хүний онцлогт тохирсон, ирээдүйн амьдралд нь бэлтгэсэн сургалтыг явуулж чаддаг уян хатан боловсролын тогтолцоо өнөөгийн нийгэмд хэрэгтэй байна.

Орчин үеийн боловсролын хамгийн чухал үүрэг ролийг сургууль, багш нар үүрэхгүй. Харин энэ нь эцэг эхчүүдэд оногддог. Хүүхдийн хөгжилд эцэг эхийн оролцоо гойд чухал бөгөөд хүүхэд сургууль дээр гэхээсээ гэртээ илүү сайн сурдаг байна. Аль ч улсын эцэг эхчүүд боловсролын чанар муу байгаагийн хариуцлагыг боловсролын яам, хичээл заасан сургуульд нь тохоодог хуучин сэтгэлгээнээсээ салж, хүүхдээ сургах ажил үйлд өөрсдөө ханцуй шамлан орох боллоо. Бид заавал бүхнийг сургууль дээрээ сурч, бүхнийг багшаар заалгах ёстой гэж үү? Гэр орондоо сурч, аав ээж, ах эгч, ном материал, интернет, компьютераас суралцаж болохгүй гэж үү? Гэрээр суралцах ажил үйл дэлхий даяар эрчимжин хөгжиж, суралцах хамгийн таатай газар сургууль байх албагүй юм гэдгийг бодит туршлагаар нотлож, дэлхийн олон орны хүмүүс сургуулиас гадуур суралцахууд суралцаж эхэллээ.

Өнөө үед хувь хүн өөрийнхөө ирээдүйг тодорхойлох болжээ. Бараг 200 гаруй жилийн турш нийгмийн амьдралын бүхий л салбарт төр давамгайлж байлаа. Харин одоо бол хүн өөрийнхөө хүслээр сонголтоо хийж, үйлчлүүлнэ. Энэ нь бас хүн өөрийн эзэмших боловсролоо өөрөө сонгоно гэсэн үг. Өөрөөр хэлбэл, хүн энэ дэлхий дээрх ямар ч сургалтын систем, аргачлал, сурах бичгийг өөрийн хүслээр сонгож, судалж болно гэсэн үг. Гэрээр суралцахууд нь суралцах эрх чөлөөг олгох бөгөөд үүний ачаар бид маргааш яах нь тодорхойгүй, өнөөгийн эмх замбараагүй энэ нийгэмд хөл алдахгүй явахад шаардлагатай мэдлэг, чадваруудыг өөрийн сонголтоор эзэмшиж чадна.

Хүүхдээ гэрээрээ сургаж, өсөлт хөгжилд нь анхаарах нь эцэг эхийн хүлээх ёстой эрхэм үүрэг мөн. Хүүхдийнхээ авъяас чадвар, оюун ухааныг нь цэцэглүүлэн хөгжүүлье!

Гарчиг

1. Гэрээр суралцахуй гэж юу вэ?

| | |
|--|---|
| Homeschooling - Гэрээр суралцахуй. | 6 |
| <i>Яагаад гэрээр суралцах ёстой гэж?</i> | |
| <i>Гэрээр суралцах нь хэнд хамгийн ашигтай вэ?</i> | |
| Сургууль ба гэрээр суралцахуй | 9 |
| <i>Чанартай боловсрол олж авах нэг арга зам -</i> | |
| <i>гэрээр суралцахуй мөн</i> | |
| <i>Гэрээр суралцах нь ямар ач тустай вэ?</i> | |

2. Гэрээр суралцах ямар арга замууд байна?

| | |
|---|----|
| Гэрээр суралцагчдыг дэмжиж, заавар зөвлөгөө өгдөг байгууллагууд | 13 |
| Гэрээр суралцагчдад зориулсан ном, сэтгүүл, гарын авлага | 14 |
| Боловсрол, сургалтын чиглэлийн интерактив, мультимедиа программ, CD-ROM -ууд | 17 |
| Сургалт, танин мэдэхүйн чиглэлээр бэлтгэсэн төрөл бүрийн VCD, DVD | 20 |
| Сургалтын зориулалттай тоглоомууд | 21 |
| Сургалтын зориулалттай компьютерийн тоглоомууд | 23 |
| Сургалт, танин мэдэхүйн интернетийн сайтууд | 24 |

3. Гэрээр суралцахуйн талаар

| | |
|--|-----------|
| <i>Хүмүүсийн бодол</i> | <i>27</i> |
| <i>Багш нараас өгөх зөвлөгөө</i> | <i>30</i> |

Гэрээр суралцахуй

Гэрээр Суралцахуй /homeschooling/ буюу хүүхдэд гэрээр боловсрол эзэмшүүлэх ажил үйл эрчимжиж эхлээд нилээд хэдэн жилийг үзлээ. Уг нь хүүхдийг гэрээр сургах нь олон нийтийн /public school/ сургууль бий болохоос өмнө аль ч улсад байсан. Харин 19-р зууны дунд үеэс олон нийтийн сургуулиуд бий болоход албан бус буюу гэрээр олгох боловсролын талаарх үзэл бодол өөрчлөгдөж эхэлжээ. Үүнээс улбаалаад 1850 оноос 1970 оныг хүртэл ихэнх эцэг эх хүүхэд нь гэрээрээ боловсрол эзэмшиж болно гэдгийг төсөөлж ч чадахаа больсон байлаа. Гэвч 1960-аад оны сүүлч, 1970-аад оны эхээр гэрээр боловсрол олж авах ажил үйл АНУ-д олон нийтийн сургуультай өрсөлдөн дахин гарч ирлээ. 1986 он гэхэд АНУ-д 120 мянга орчим хүүхэд л гэрээр суралцаж эхэлж байсан бол өнөөгийн байдлаар АНУ-д 1,5 сая хүүхэд, дэлхийд олон зуун мянган хүүхэд гэрээр суралцаж, энэ тоо цаашид улам хурдацтай өсөх хандлагатай байна. Мөн Австрали, Бразил, Канад, Хятад,

Коста Рика, Чех, Египет, Франц, Герман, Энэтхэг, Израил, Итали, Япон, Малайз, Мексик, Шинэ Зеланд, Нидерланд, Норвейг, Шотланд, Сингапур, Өмнөд Африк, Тайланд, Англи зэрэг орнуудад гэрээр сурч боловсрох ажил үйлийг дэмжсэн олон нийтийн байгууллагууд, чиглэл, зөвлөгөө өгөх олон зуун төвүүд байгуулагдаж эхэлсэн байна. Мөн бие даан суралцах хүсэл эрмэлзэлтэй сурагчдад их, дээд, дунд, бага сургуулиудын зүгээс дэмжлэг үзүүлж, сургалт явуулах боллоо.

Яагаад гэрээр суралцах ёстой гэж ?

Нэгдүгээр үндэслэл:

Хүн бүр өөр хоорондоо адилгүй, давтагдашгүй нэг бодьгал юм.

Тэдний сонирхол, суралцах стиль, анхаарал төвлөрүүлэлт, өсөлтийн хурд, өсөн хөгжих процесс, дуртай амттан нь ч өөр байдаг. Зарим нь 5 настайдаа уншиж сурсан байхад өөр бусад нь 7, 10 настайдаа уншиж сурч болно. Зарим нь төрөлхийн л тамирчин болох авъяастай байхад зарим нь тийм зүйлд

огтоос бүтэлгүй байж болно. Нэгэнд нь пуужин таалагдаж байхад өөр нэгэнд нь шавж, гурав дахид нь Грекийн домог таалагдаж байх жишээтэй. Нэг нь математикт үнэн голоосоо дургүй байхад өөр нэгэнд нь тооны ухаанаас илүү зүйл байдаггүй мэт санагдана. Тэгвэл эдгээр бүх хүүхдэд таарах сургалтын ямар хөтөлбөр байх ёстой вэ? Гэрээр суралцагчдын хувьд өөртөө зориулан өөрийн гэсэн сургалтын хөтөлбөрийг зохиож болно. Гэрээр суралцагчийн сургалтын хөтөлбөрт тухайн хүнийг 1-рт тавьж үзнэ. Энд багш юуг чухал гэж үзэн заах гэж байгаа нь гол биш, харин тухайн хүн юуг сурч байна, юуг сурч мэдэхийг хүсэж байна, юунд илүү авъяастай байна вэ? гэдэг нь гол юм.

Хоёрдугаар үндэслэл:

Сүүлийн үеийн мэдээллийн технологийн ололт нь хүн бүрт хүссэн цагтаа, хүссэн газартаа суралцах боломжийг олгосон. Өнөөдөр хүн төрөлхтний түүхэнд анх удаа, бид дэлхий дээр хуримтлагдсан, хэрэгцээт бүх мэдээллийг хэрхэн хадгалах, тэр мэдээллийг дэлхийн ямар ч хүн, агшин зуур дурын

хэлбэртэйгээр хэрхэн олж авахыг мэдэж байна. Интернетэд хандах боломжтой компьютер бүр агуйн хананд хүн зураг зурж байх үеэс эхлэн 30000 жилийн бүх хүн төрөлхтний шинжлэх ухаан, бизнес, урлагийн салбарт хуримтлуулан цуглуулсан бүх мэдлэгийг олж авах, мөн дэлхийн янз бүрийн орны 59 сая багш нар, тэдгээрийн 2 тэрбум гаруй шавь нарын цуглуулсан авьяас билэг, эрдэм ухааны санг ашиглаж болно. Энэ нь хэн ч гэсэн гэртээ суугаад суралцах боломжийг олгож байгаа юм.

Гуравдугаар үндэслэл:

Гэрээр суралцагч нь өөрт тохирох арга барилаар, өөрт таалагдсан хэрэгслийг ашиглан хүссэн зүйлдээ суралцаж болно.

Гэрээр суралцагч нь асар олон төрлийн сургалтын арга хэрэгслээс чөлөөтэй сонголт хийх бололцоотой байдаг. Та суралцахдаа ямар ч хэл дээрх ном, дасгал ажлын дэвтэр, компьютерийн программ, тоглоом, VCD, DVD хичээлийг ашиглаж болно. Мөн орон дээрээ хэвтээд, газар суугаад, зурагтаа үзээд, гадуур алхангаа ч сурч болно.

Дөрөвдүгээр үндэслэл:

Гэрээр суралцагч нь бие даан суралцах чадвар, суралцах арга барилыг эзэмшдэг.

Сургууль дээрээ бүх зүйлийг сурч авдаг, эмнэлгээр эмчлүүлдэг, өмгөөлөгчөөс хуулиа асуудаг боловсролоор өнөөгийн аав ээжүүд хүмүүжиж ирсэн. Харин үр хүүхдүүдийнх нь хувьд энэ ойлголт өөрчлөгдөж байна. Компьютер бидний заавраар олон үйлчилгээг үзүүлж, татвараа төлж, хувьцаа худалдан авч чадна. Эрүүл сэтгэлгээтэй хүний эрүүл мэнд өөрөөс нь шалтгаалж, ямар хоол идсэн, юу уусан, биеийн тамираар хичээллэж байгаа эсэхээс нь хамаарч байдгийг ойлгодог болжээ. Гэрээр суралцахуй нь хүүхдийг өөрөө хийе гэсэн бүтээлч сэтгэлгээтэй болгон төлөвшүүлнэ.

Гэрээр суралцах нь хэнд хамгийн ашигтай вэ?

Сургуулийн өмнөх насны хүүхэд:

Хүүхэд амьдралынхаа эхний 4 жилд өөрийн чадварынхаа 50%-ийг, 8 хүртэлх насанд 30 %-ийг олж авах боломжтой байдаг. Нөгөө талаас

энэ насны хүүхдүүдийн хувьд гэр орон нь сурч, хөгжих үндсэн орчин нь болдог тул гэрээр суралцах нь тэдний хувьд амин чухал асуудал мөн.

Сургуулийн насны хүүхэд:

Сургуульд заалгасан хичээлээ бататган давтах, өөрийн хүсэл сонирхлын дагуу, өөрт хэрэгтэй өөр бусад зүйлд бие даан, бүтээлчээр суралцах, сонирхон судлах бололцоог гэрээр суралцахуй олгоно.

Оюутан залуус болон насанд хүрэгчид:

Орчин үед аливаа хүн насан туршдаа суралцаж, өөрийгөө боловсруулж байх шаардлагатай болжээ. Цаг үеэсээ хоцрохгүй, цаг үедээ гологдохгүй байхын тулд ажлынхаа зав чөлөөгөөр гэрээрээ өөрийгөө хөгжүүлэн, боловсрох нь шинэ зууны иргэний хувьд хэвийн зүйлийн нэг байх ёстой.

Сургууль ба гэрээр суралцахуй

Хүүхэд, багачуудад ерөнхий боловсрол олгох байгууллага нь **сургууль** /school/ билээ. Одоо дэлхий нийтээр **public** /олон түмнийг хамарсан/ **private** /хувийн/, **home** /гэрийн/ school гэсэн үндсэн 3 хэлбэрийн сургууль байдаг.

Ихэнх улс орнууд хүүхэд багачууддаа ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй олж авах боломжоор хангахыг хичээдэг бөгөөд энэ үүрэг хариуцлагыг **public school** буюу улсын ЕБС-ууд үүрдэг. Хүүхэд багачуудыг бие хүн болон төлөвшихөд зайлшгүй хэрэгтэй мэдлэг, чадвар, соёлын үнэт зүйлсийг сургалтын дэвшилтэт арга технологээр, мэргэшсэн багш нараар дамжуулан үнэ төлбөргүйгээр эзэмшүүлэхийг зорьдог public school-ынхан үнэхээр гавьяатай үйлстэнгүүд билээ. Гэвч үнэ төлбөргүй боловсрол олгодог public school байсаар байтал нэмэлт төлбөр авч, боловсрол олгодог хувийн сургуулиуд /**private school**/ олноор байгуулагдах болсоны учир юу вэ?

Үүний учир нь боловсролд зарцуулж байгаа мөнгөнд оршино. Монгол улсын төрөөс өөрийн орны эдийн засгийн чадавхиас шалтгаалан, үнэ төлбөргүй боловсрол олгох энэ ажил үйлд зориулж, ЕБС-ийн нэг хүүхдэд жилд 60-80 мянга орчим төгрөг төсөвлөн гаргаж чаддаг. Төсөв нь бага тул анги дүүргэлт өндөр /нэг ангид 35-40 хүүхэд/ материаллаг бааз сул, багшийн цалин бага зэрэг бэрхшээл, дутагдалтай талууд их гарч ирнэ. Улмаар эдгээр нь үйлчилгээнийх нь чанарт нөлөөлдөг байна. Үүнээс шалтгаалаад хүүхэддээ чанартай боловсрол эзэмшүүлье гэж зорьсон эцэг эхүүд нэмэлт төлбөр төлөн хувийн сургуульд хүүхдээ оруулдаг. Нэмэлт төлбөрийг анги танхимын үзэмж, сургалтын хэрэглэгдэхүүн, өндөр хурдтай компьютер, арвин баялаг номын сан, өндөр цалин авдаг ур чадвар өндөртэй багш нар, анги дүүргэлт бага, хичээл, давтлагын цаг нь их байлгах үүднээс төлдөг. Гэвч хувийн сургуулиуд эцэг эхчүүдийн энэ итгэл, хүслийг төдийлөн сайн хангаж чадахгүй

байсаар өнөөг хүрлээ. Учир нь:

1-рт: Манай улсын хувьд хувийн ЕБС-ууд жилд 300-1000 орчим долларын төлбөртэй байдаг. Манайх шиг буурай орны хувьд энэ нь нилээд их хэмжээний мөнгө тул хувийн сургуулиуд 200-500 орчим /улсын ЕБС 2000-4000 орчим/ сурагчтай байдаг. Хүүхдийн тоо цөөн байх нь сурагчийн төлсөн төлбөрийн ашигтай зарцуулалтыг бууруулна. Улмаар чанартай боловсрол эзэмшүүлэхэд зориулан гаргасан эцэг эхийн чармайлтын үр дүн буурдаг.

2-рт: Хувийн сургуульд бэрхшээлийг даван туулах чадвар султай, эрх танхи хүүхдүүд олноор ордог. Энэ нь нэг нэгнийхээ суралцах хүсэл тэмүүлэл, сурлагын чанарт муугаар нөлөөлнө. Чадварлаг багш нар, сайн сургалтын орчинтой ч сурлагын чанар нь төдий л сайнгүй байх юм.

Энэ мэт шалтгаанаар улсын ч, хувийн ч сургууль нь сэтгэлд нэгл хүрдэггүй. Энэ мухардлаас гарах зам байна уу?

Чанартай боловсрол олж авах нэг арга зам - гэрээр суралцахуй мөн

Боловсролын чанар муу байгаагийн хариуцлагыг боловсролын яам, хичээл заасан сургуульд нь тохоодог хуучинсаг сэтгэлгээгээ орхиё!

ЕБС-иуд стандарт хөтөлбөрийн дагуу, хүнд хэрэгтэй хамгийн гол зүйлсийг зааж сургадаг. Иймээс сургуульд явж, суралцах нь үнэхээр чухал зүйл мөн. Гэвч сургууль сурагч бүрийн сонирхол, сурах арга барил, өсөлтийн хурд, ирээдүйд эзэмших мэргэжил зэрэгт тохирсон, хүн бүрийн хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалт явуулж чадахгүй. Ийм боломж ч үгүй. Бид яагаад заавал бүхнийг сургууль дээрээ сурч, бүхнийг багшаар заалгах ёстой гэж? Гэр орондоо сурч, аав ээж, ах эгч, ном материал, интернет, компьютераас суралцаж болохгүй гэж үү? Өглөө ЕБС-д гол гол зүйлсийг заалгачихаад, өдөр ирээд өөрийн сонирхолтой, өөрт хэрэгтэй зүйлсийг нэмж судалж болох уу? Бид хэт их бэлэнчлэх сэтгэлгээтэй байгаа юм биш биз.

Гэрээр суралцах нь ямар ач тустай вэ?

1. Гэрээр суралцагчдын гол багш нь эцэг эх юм. Эцэг эхүүд суралцах ажил үйлд нь тусалснаар хүүхэдтэйгээ илүү олон цагаар, илүү ойр дотно байх бололцоо бүрддэг.

2. Хүүхэддээ хичээл заадаг эцэг эх цаг үетэйгээ хөл нийлүүлэн хөгжиж боловсорч чаддаг. Би үүнийг мэдэхгүй. Яаж хүүхэддээ заанаа гэж айх хэрэггүй. Аливаа нэг зүйлийг сурах хамгийн амархан арга нь бусдад заах юм. Та хүүхэддээ багаас нь англи хэл заавал өөрөө ч англи хэлтэй болно.

3. Та хүүхдийнхээ гэрээр сурч боловсрохыг дэмжвэл зөвхөн өөрийн хүүхдэд онцгойлон зориулсан сургалтын хөтөлбөр зохиож болно. Хүүхдийн сурах хурд, суралцах стиль, хөгжлийн түвшин зэрэгт нь зохицсон сургалт жинхэнэ оновчтой сургалт болж чаддаг.

4. Гэрээр суралцах үйл ажиллагаа нь амьдралын хэв маягт тохирсон уян хатан байдаг. Өнөөдөр толгой өвдөөд байвал тэр хичээлийг хийхгүй ч байж болно. Эсвэл тухайн үед хүүхэд

тэр зүйлийг огт сонирхохгүй байвал дараа сонирхсон үед нь судалж болно шүү дээ.

5. Ирээдүйд эзэмших ажил мэргэжилд нийцүүлж болно. Эмч болох гэж 6 настайгаасаа тусгай программаар бэлдсэн хүүхэд, 10-р ангиа төгсөөд эмч болохоор шийдсэн хүүхэд хоёрын хөгжлийн түвшин тэс өөр байх нь ойлгомжтой.

6. Гэрээр суралцахад суралцагчийн хүсэл сонирхлыг онцгойлон анхаардаг. Хүүхдийг хүчээр сургах, хүслээр нь сургах хоёр хоорондоо эрс ялгаатай. Хүсэл, сонирхолдоо хөтлөгдөн суралцагч нь ядрах, залхуурахыг мартан үр дүнд хүрдэг.

7. Гэрээр суралцагчийн хувьд бүх зүйл чөлөөт сонголттой. Би ямар ч арга барилаар, ямар ч номоор, юуг ч сурч болно.

Гэрээр суралцах арга замууд

Гэрээр суралцагчдыг дэмжиж, заавар зөвлөгөө өгдөг байгууллагуудад хандаж болно

Дэлхийн олон оронд гэрээр суралцагчдыг дэмжин, тусалдаг янз бүрийн байгууллагууд байдаг бөгөөд тэдгээрийн заримаас нь дурдвал:

1. АНУ-ын байгууллагууд ***American Homeschool Association /AHA/*** Энэ байгууллага өөрийн улсын муж бүрийн гэрээр олгох боловсролын талаар хууль тогтоомж, чиглүүлэг зөвлөгөө өгөх холбоо, төвүүдийн хаяг, утас, ном, эх материалын талаар зэрэг өргөн хүрээний мэдээлэл өгдөг. Мөн эндээс сар тутмын on-line сонин эрхлэн гаргадаг.

Веб хуудас нь: www.home-ed-press.com/AHA/aha.html

Family Unschoolers Network

/F.U.N/ Энэ байгууллага бие даан суралцагчид, гэрээр суралцагчдыг дэмжиж, мэдээлэлээр хангадаг.

Боловсролын талаарх үзэл бодол, эрэгцүүлэмж зэргийг багтаасан F.U.N news хэмээх сэтгүүлээрээ

алдартай. Мөн эндээс F.U.N books гэсэн гэрээр суралцагчдад зориулсан цуврал номууд олноор хэвлэгдэн гардаг.

Веб хуудас нь: members.aol.com/FUNNews/index.html

National Home Education Research institute /NHERI/

Ашгийн бус энэ байгууллага гэрээр суралцагч гэр бүл, хүүхдүүдийн талаар судалгаа хийж, мэдээлэл цуглуулдаг. NHERI нь гэрээр суралцагчдад зориулсан мэдээлэл, товхимол, баримтууд эмхлэн бэлтгэдэг.

Мөн эднийхээс The Home School Researcher хэмээх улирал тутмын чанартай сэтгүүл гаргадаг.

Веб хуудас нь: www.nheri.org

National Homeschool Association /NHA/

Энэ байгууллага гэрээр суралцагчдад заавар зөвлөгөө өгч, боловсролд чөлөөт сонголт хийхэд нь тусладаг.

Веб хуудас нь:

www.alumni.caltech.edu/~casner/nha

Holt Associates

Энэ байгууллага гэрээр олгох боловсролын нэрт зүтгэлтэн John Holt-ын үүсгэл санаачлагаар байгуулагдсан бөгөөд хүүхэд

гэрээрээ, хэвшмэл сургалтын хөтөлбөргүйгээр сурч, боловсорч болно гэж үздэг. Эднийхээс 2 сартутмын Growing Without Schooling сэтгүүл, John Holt’s Bookstore хэмээх үнэгүй номын каталог гаргадаг.

Веб хуудас нь: www.holtgws.com
Alliance for Parental Involvement in Education/ALLPIE/

Ашгийн бус энэ байгууллага public, private, home аль ч сургуулийн хувьд хүүхдийн сурч боловсрох үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэхийг хичээдэг. Мөн энэ байгууллага боловсролын үзэсгэлэн яармаг, семинаруудыг ивээн тэтгэж, ном, эх сурвалжуудын каталог гаргадаг. Веб хуудас нь: www.croton.com/allpie

Home school Legal Defense Association

Гэрээр сурч боловсрох үйл ажиллагаатай холбоотой хууль, эрх зүйн зөвлөгөө өгч тусалдаг. Веб хуудас нь: www.hslda.org

2. Өөр бусад орны
байгууллагууд

Society of home school friends

Энэ байгууллагын идэвхтэй үйл ажиллагааны ачаар 1998 оны 9 сараас Чехт албан ёсны гэрийн сургалт эхэлсэн.

Веб хуудас нь: **Ucime se doma Alternative Learning Organization**

Европт идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа, чөлөөт гишүүнчлэлтэй байгууллага
Association for Freedom in education

Испанийн энэ байгууллага боловсролын эрх чөлөөг дэмжиж үйл ажиллагаагаа явуулдаг.

ALE, Apdo. 68, 08880 Cubelles, Barcelona, Spain

/La Asociaciyn para la Libre Educaciyn es una asociaciyn registrada en Diciembre de 2002 en Espaca que defiende el derecho a Educar en el Hogar. /

MATS

Энэ нь гэрээр суралцагчдын Шведийн холбоо бөгөөд гэрээр суралцагчдыг дэмжиж, тэдэнд хууль тогтоомжийн болон суралцах эх сурвалжуудын талаар зөвлөгөө өгдөг.

Bildung Zu Haus Die Schulalternative

Энэ нь Швейцарын гэрээр суралцагчдын холбоо юм. Гэрээр суралцагчдад зориулсан зөвлөгөө өгч, гарын авлага, сэтгүүл, мэдээ гаргадаг.

Home Education Association Inc/HEA/

HEA нь 2001 оны 4-р сард

Австралийн гэрээр суралцагчдыг дэмжих, тэдэнд зориулсан үйл ажиллагаа явуулах зорилгоор байгуулагдсан.

***Association of Canadian Home-Based Education /ACHBE/
Yukon Home Educators Society /YHES/***

Канадын энэ хоёр байгууллага 1989 онд байгуулагдсан бөгөөд гэрээр суралцагчдад зөвлөгөө өгөх, ном гарын авлагаар хангах, гэрээр суралцагчдын хамтын ажиллагаа, бүлгээр ажиллахыг дэмждэг.

Japan Home School Support Association

Энэ байгууллага Японд гэрээр суралцах үйл ажиллагааг хөгжүүлэх зорилгоор ажиллаж байна. Эндээс сэтгүүл, номын жагсаалт гаргаж, семинар, симпозиумуудыг зохион байгуулдаг.

Tokyo Shure

Tokyo Shure нь японы чөлөөт сургууль бөгөөд энэ сургуулийс Home Shure хэмээх сүлжээ байгуулж, одоогоор 550 гэр бүл үйл ажиллагаанд нь хамрагдаж байна.

Home Education UK

Англид гэрээр суралцах ажил эхлээд 20-иод жилийн нүүрийг үзэж байгаа бөгөөд одоо 150,000

орчим хүүхэд гэрээр суралцаж байна. Гэрээр суралцагчдыг дэмжиж тусалдаг нилээд олон байгууллага Англид бий.

Oppo omaan tahtiin

Гэрээр суралцагчдыг дэмжсэн үйл ажиллагаа явуулдаг Финляндын байгууллага.

/unschooling-oppimisesta perheen kesken (kotikoulu) paljon alle oppivelvollisuuidstd alkaen, miten kotikoulu sujuu kdytdnnccsd, Montessorin, Freinet'n ajatuksista sekд omaan tahtiin oppimisesta kunnallisissa kouluissa/

Гэрээр Олгох Боловсрол Төв

Энэ төв нь хүүхэд, залуучууд, насанд хүрэгчдийн гэрээр суралцах үйл ажиллагааг дэмжих, эцэг эхчүүдийн гэрээр хүүхдээ сургах ажил үйлд тус болох, энэ талын үйл ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх зорилготойгоор байгуулагдсан монголын төрийн бус байгууллага юм.

Гэрээр суралцагчдад зориулсан ном, сэтгүүл, гарын авлага зэргийг ашиглаж болно

Энэ сэдвээр хэвлэгдсэн хэдэн зуун мянган ном, сэтгүүлээс та хүссэнээ захиалан авч болно. Гэрээр суралцагчдад

зориулсан сэтгүүлүүд нь эцэг эх, хүүхдэд хэрэгтэй мэдээлэл, сүүлийн үеийн шинэ ном, сургалтын хэрэгсэл, гэрээр хичээллэгч хүүхдүүд болон хүүхдээ гэрээр сургагч эцэг эхүүдийн үнэт зөвлөгөө, туршлага зэргээс өгүүлсэн байдаг. Харин гэрээр суралцагчдад зориулсан төрөл бүрийн номууд нь хүүхэд бие даан үзэхэд хялбар, эсвэл эцэг эхчүүд хүүхдээ сургах ажил үйлдээ ашиглаж болохоор, өнгө дүрс, өгүүлэмж сайтай номууд байдаг.

Олонд нэртэй хэдэн сэтгүүлийг дор дурдвал:

Home Education Magazine

Энэ сэтгүүл 60 орчим хуудастай байх бөгөөд хоёр сард нэг дугаар гарна.

Веб хуудас нь: www.home-ed-press.com

Homeschooling today

Хоёр сар тутмын энэ сэтгүүл бүх насны сурагчдад зориулсан мэдээлэл, зөвлөгөөтэй.

E-mail: hstodaymag@aol.com

Early Childhood Today

Энэ сэтгүүл сургуулийн өмнөх насны хүүхдүүдийг хэрхэн хөгжүүлэх талаар заавар зөвлөгөө, сургалтын хөтөлбөр зэргийг санал болгодог.

F.U.N News

F.U.N гэдэг нь Family Unschoolers Network гэсэн байгууллагын нэрийн товчлол бөгөөд энэ байгууллагынхан аливаа сургалт хөгжилтэй, зугаатай байх ёстой гэсэн үзлийг чиг шугамаа болгодог. Ийм утгаараа энэ сэтгүүлд гэртээ хэрхэн чөлөөтэй, зугаатай суралцаж болох талаар заавар, зөвлөгөө их байдаг. Веб хуудас нь: members.aol.com/FUNNews/index.html

Growing Without Schooling /GWS/

Энэ нь гэрээр олгох боловсролыг дэмжиж гарч ирсэн хамгийн анхны сэтгүүл бөгөөд 1977 онд анхны дугаараа гаргасан гэдэг. Homeschool -ийг public болон private school -тэй эн зэрэгцүүлж, хууль тогтоомжоор хүлээн зөвшөөрүүлэхэд энэ сэтгүүл, түүнийг үүсгэн байгуулагч John Holt их үүрэг гүйцэтгэсэн гэж үздэг.

Веб хуудас нь: www.holtgws.com

The Mailbox

Багш нарт зориулагдсан энэ сэтгүүл заах арга зүйн зөвлөгөө, хичээлийн төлөвлөгөө зэргийг багтаасан байх бөгөөд preschool, kindergarten, primary grades/1-3/, intermediate grades /4-6/ гэсэн 4 ангилалаар гардаг.

Веб хуудас нь:

theeducationcenter.com

Mothering

Natural family Living байгууллагын энэ сэтгүүл жирэмсэн байхаас төрөх хүртэл, аав ээж болох нь, гэр бүлийн амьдрал, хүүхдийн эрүүл мэнд, суралцахуйн эх сурвалжууд, боловсролын алтернатив сонголтууд, гэрээр олгох боловсрол зэрэг бүлэг сэдвүүдтэй.

e-mail: mother@ni.net

Practical Homeschooling

Гэрээр суралцахуйд зориулсан сургалтын хэрэгслүүдийг дэлгэрэнгүй тайлбарласан, хичээлийн төлөвлөгөө, зөвлөгөө зэргийг багтаасан байдаг. A day at our house буландаа янз бүрийн гэрээр суралцагч гэр бүлүүдийн нэг өдрийн амьдралын харуулдаг.

Веб хуудас нь:

www.home-school.com


Гэрээр суралцахуй болон гэрээр олгох боловсролтой холбоотой ном, материалуудыг alternatives in education, home school source book, homeschooling handbook, Deschooling, unschooling, freedom in education, schooling at home гэсэн нэр хаягтайгаар хайж болох юм. Гэрээр суралцагчдад хэрэг болох хэдэн номыг жишээ болгон дурдвал:



Homeschooling for Success: How Parents Can Create a Superior Education for Their Child

Энэ номын зохиогч нь

Robert T. Kiyosaki, Rebecca Kochenderfer нар юм. Robert T. Kiyosaki-г “Баян аав, ядуу аав” номын зохиогч гэдгээр нь хүмүүс сайн мэдэх байх. Харин Rebecca Kochenderfer бол Homeschool.com-г үндэслэгч. Энэ ном гэрээр суралцаж эхлэх гэж байгаа хүн бүхэнд хэрэгтэй бүх зүйлсийн талаар өгүүлэхийг зорьсон, гэрээр суралцах замаар шилдэг боловсролыг хэрхэн эзэмшиж амжилтанд хүрэхийг өгүүлжээ.




Teach Your Own - The John Holt Book of Homeschooling.

Гэрээр олгох боловсролын эцэг гэгддэг John


Holt-н 1981 онд хэвлэгдсэн The Beginner's guide to homeschooling хэмээх алдарт номыг Holt associate-н тэргүүн Patrick Farenga шинэчилэн сайжруулж “Teach your own” буюу өөрөө өөртөө заа гэсэн нэртэйгээр хэвлэн гаргасан

байна. Уг ном шинэ мэдээлэл, эх сурвалжаар нилээд баяжигджээ




Learning All the time: How small children begin to read, write, count, and investigate the world, without being taught

Энэ 169 хуудастай ном John Holt-ын хамгийн сүүлчийн бүтээл. Уг номд бага насны хүүхэд хэрхэн уншиж, бичиж, тоо бодож сурдаг талаар, мөн хүн насан туршдаа хүүхэд нас шигээ л алхам тутамдаа шинэ зүйлд суралцаж байх ёстой зэргийг өгүүлсэн.



The Unschooling handbook: How to use the whole world as your child's classroom

Mary Griffith-н зохиосон энэ номд хүүхдийн эрдмийн өргөө бол дэлхий, бид бүх дэлхийгээс суралцах ёстой гэсэн санааг гаргажээ.



The Complete Home Learning source book

Энэ номын зохиогч болох Rebecca Rupp өөрийн 3 хүүхдийг

10 гаруй жил гэрээр сургаж, энэ талын нилээд туршлага хуримтлуулсан, улмаар боловсрол судлалын доктор цол хүртсэн хүн. Энэ номд тооны ухаанаас амьтан судлал хүртэл бүхий л хичээлээр гэрээр суралцахад хэрэг болох ном, гарын авлага, интернетийн сайтууд, тоглоом, аудио, видео хуурцаг, программ хангамж зэргийн талаар дэлгэрэнгүй танилцуулсан байна.

Боловсрол, сургалтын чиглэлийн интерактив, мультимедиа программ, CD-ROM уудыг ашиглаж болно

Асер группын тэргүүн Стэн Шин “Интерактив мультимедиа системээр зэвсэглэсэн хөгжиж байгаа улс орнууд үйлдвэрлэлийн эринийг шууд алгасаж ч чадахаар болжээ” гэж дуу алдан өгүүлсэн байдаг. Үнэхээр шинэ медиа технологи гарч ирсэн нь хүн төрөлхтөнд шинэ ертөнц, шинэ боломжийг нээж өгсөн юм.


Компьютерийн шинжлэх ухаанд мэдээллийг текст, дуу, зураг, хөдөлгөөнт дүрслэл, видео зэргийн хослолыг ашиглан үзүүлэхийг *мультимедиа /multimedia/* гэнэ. Харин

интерактив /interactive-харилцаж ажиллах/ хэмээх үг нь компьютер ба түүнийг хэрэглэгчийн хооронд хоёр чиглэлд мэдээллийг дамжуулах хэрэгслийг хэлдэг. Интерактив программ нь хэрэглэгчийн тавьсан асуулт, өгсөн командад хариулт өгөх чадвартай байдаг.

Интерактив, мультимедиа технологийг ашиглан бүтээгдсэн лавлах материал, нэвтэрхий толь, сурах бичиг, гадаад хэлний хичээл зэрэг нь сургалтын гайхалтай сайн хэрэгсэл бөгөөд ямар ч багшийг орлож чадахаар болжээ.

Интерактив, мультимедиа программуудыг CD-ROM хэмээх зэрэнцэг хэлбэрийн мэдээлэл хадгалах хэрэгсэл дээр хуулан авч болох бөгөөд 640 мегабайтын зэрэнцэг нь 500 шилдэг номыг багтаах боломжтой.


Сүүлийн үеийн сургалтанд өргөн хэрэглэгдэх болсон интерактив, мультимедиа зарим программуудын талаар товч танилцуулъя.



Microsoft Encarta Deluxe 2005


Энэ бол дэлхийд программ хангамжаар тэргүүлэгч

Microsoft компани, дэлхийн шилдэг 4500 эрдэмтэн, судлаачидтай хамтран бүтээсэн нэвтэрхий толь юм. Encarta жил жилд шинэчлэгдэн гардаг бөгөөд мэдлэгийн бүхий л салбарыг хамарсан, бүрэн хэмжээний лавлах юм.




101 languages of the World

Энэ нь Transparent Language компанийн бүтээл бөгөөд дэлхийн 101 хэлээр 140,000 үг, 25,000 хэллэгийг багтаажээ. Мөн үг, өгүүлбэр бүрийг унаган хэлтэй хүн хэлэх, хэллэгүүдийг хооронд нь харьцуулж болохоор зохиогдсон энэ программыг гадаад хэл судлаачид ашиглах дуртай байдаг.





Learn to speak English 9

Энэ нь The Learning Company-ий бүтээл бөгөөд англиар ярьж сургах интерактив хичээл юм.




Easy Translator Deluxe 4

Энэ нь Transparent Language компанийн бүтээл бөгөөд Испани, Франц, Англи, Итали, Португали, Япон хэл дээрх текстүүдийг хооронд нь хөрвүүлнэ.



Interactive Learning

компани сурагчдыг интерактив хэрэгслийг ашиглан физик, хими, биологи зэрэг байгалийн шинжлэх ухаанд суралцахад нь зориулж өөрсдийн бүтээгдэхүүнийг гаргадаг бөгөөд одоогоор ChemTutor, PhysicsTutor, BioTutor хэмээх интерактив програмуудыг зохиогоод байна.



Mind Power Math

Энэ нь The Learning Company -ны бүтээл бөгөөд сурагчдыг бие даан өөрийгөө хөгжүүлэхэд зориулж

математикийн хичээлээр алгебр, геометр, тригонометр, тооцон бодох гэсэн бүлэг сэдвүүдийг багтаан зохиогджээ.




Making Music:

/create, play, experience/

Энэ нь Viva Media компанийн бүтээл бөгөөд нэрт хөгжмийн зохиолч Morton Subotnick-н санаагаар хийгджээ. 16 хөгжмийн зэмсэг, 23 хэрэгслийг ашиглан хөгжмийн ая зохиож сурах ба хөгжмийн хэмнэл, ая, хөгжмийн зэмсэг зэрэг зүйлсийн талаар мэдэж авна.

3D World Atlas




Энэ программ нь дэлхийг урьд өмнөхөөс чинь илүүтэйгээр танин мэдэхэд тусална. Хиймэл дагуулаас авсан газар зүйн

нарийвчлал өндөртэй зургууд, газар орны талаар дэлгэрэнгүй мэдээлэл зэргийг Global Software publishing компани интерактив хэлбэрээр бэлтгэжээ.



History of the world

Энэ нь Dorling Kindersley компанийн дэлхийн түүх хэмээх номын интерактив хувилбар нь юм. Өнгө дүрслэл сайтай номуудаараа алдартай энэ компанийн номуудыг CD-ROM буюу интерактив программ хэлбэртэй болгох эрхийг Global Software Publishing компани эзэмшдэг.



DK GCSE Biology

Биологийн хичээлээр төгсөлтийн шалгалтанд бэлтгэгчдэд

зориулсан интерактив программ. Эс, хүний биеийн анатоми, ургамал судлал, генетик, эволюци гэсэн сэдвүүдийг хамарч, 1500 гаруй асуулт, төрөл бүрийн заавар, зөвлөгөө, онолын бүх сэдвийг багтаажээ.

Үүнтэй адил математик, хими, физикийн хичээлүүдээр шалгалтанд бэлтгэх программ бас гарсан.


Сургалт, танин мэдэхүйн чиглэлээр бэлтгэсэн төрөл бүрийн VCD, DVD-г ашиглаж болно

Мэдээллийн технологийг сургалтанд хэрэглэж байгаа нэг хувилбар нь VCD, DVD хичээл юм. Зурагтынхаа өмнө суугаад кино хэлбэрээр зохиогдсон хичээлийг үзэж, судлах нь сурагчдад сонирхолтой, мөн илүү үлдэцтэй байдаг. Жишээ нь түүхийн сэдэвтэй 1 цаг 30 минут үргэлжилдэг киногоор хэдэн зуун жилийн түүхийг харуулж болно. Мөн ийм хичээл нь ойлгож, төсөөлөхөд хялбар, урт хугацаагаар хоногшин үлдэнэ. Сургалтанд ашиглаж болох хэдэн VCD, DVD-г жишээ болгон дор дурдъя:



Universe


Энэ DVD нь орчлон ертөнцийн нууцын талаар Stephen Hawking болон өөр бусад эрдэмтийн өгүүлсэн 6 хэсэгтэй бүтээл юм.



Ultimate guide Volcanoes

Энэ VCD нь Discovery компанийн бүтээл бөгөөд галт


уулын талаарх хамгийн сүүлийн үеийн мэдээ, материалыг ашигласан, түүний талаар иж бүрэн ойлголт өгөхөд чиглэсэн байна.



Elements

Энэ CD-ROM нь химийн элементүүд, үелэх системийн


талаар кино, программ зэргийг багтаажээ.



100 greatest discoveries

Энэ нь Science TV-н бүтээл бөгөөд генетикээс сансар


судлалыг хүртэлх бүх шинжлэх ухааны хамгийн агуу гэсэн 100 нээлтийн талаар өгүүлнэ.



Bacteria

Энэ кино программ бактери хэмээх өчүүхэн амьтдыг нүдээр үзэх боломжийг


олгоно. Мөн эдгээр бичил биетүүд бидний амьдралд ямар их үүргийг гүйцэтгэдэг, хэрхэн хувилж, үрждэг, антибиотик гэж юу болох, ер нь л бактеритэй холбоотой бүх зүйлийг мэдэж авна.



History of Earth

Энэ бүтээлд дэлхийн түүх, тектоникийн х ү ч ,

эволюцийн ул мөр, эрдэс чулуулаг, хөрс гээд олон олон зүйлийн талаар өгүүлжээ.



Genetics

Генетикийн өвчин, cloning-н ёс зүйн а суудал ,

генетикийн шинжлэх ухааны ололтууд, түүнийг хэрхэн ашиглаж болохоор байгаа зэрэг олон зүйлсийн талаар энэ бүтээлд өгүүлжээ.

Сургалтын зориулалттай тоглоомуудыг хэрэглэж болно

/Educational toys/

Хүүхдийг тоглож байгаа тоглоомоор нь дамжуулан ямар нэг зүйлд сургаж, хөгжүүлж болдог. Хүсэл, сонирхолдоо хөтлөгдөн тоглож байгаа хүүхэд ядрах, залхуурахыг мартан, өөрөө ч анзааралгүй суралцдаг. Иймээс сүүлийн үед сургалтыг тоглоомтой хослуулахыг хичээх болжээ.

Baby Farm Friends Bowling



Энэ тоглоом нь 18-48 сартай хүүхдүүдэд амьтдад танилцах боломжийг олгоно. Мөн амьтад дээр 1-6 гэсэн тоонууд бичсэн нь тоо тоолж сурахад нь тустай.



Baby Grand Piano

Хүүхдийн жижиг гарт тохирохоор бага хийгдсэнээс гадна жинхэнэ төгөлдөр хууртай яг адил дуу авиаг гаргах энэ тоглоом нь 3-аас дээш насны хүүхдүүдийг хөгжмийн авъяасаа хөгжүүлэхэд нь тус болдог.

Beauty Shop Accessory Kit



Энэ тоглоом нь 6-аас дээш насны охидууд зориулагдсан бөгөөд багаасаа өөрийн үс зүсэндээ анхаарч, гоо сайхны мэдрэмжтэй болоход нь тусална.

Add and Subtract, Multiply and Divide magnets



Энэ тоглоомоор нэмэх, хасах,

үржих, хуваах гэсэн математикийн 4 үйлдлийг хийж сурна.



Brain station

Энэ ярьдаг тоглоом интерактив технологи дээр үндэслэгдсэн найрсаг багш юм. Газарзүй, математик, соёл урлаг, хэл зэрэг 32 сэдвээр мэдлэг олгоно. Энэ тоглоомийг 6-аас дээш насны хүүхдэд зориулжээ.



Mega Science Lab

Энэ нь 10-аас дээш насны хүүхдүүдэд зориулсан тоглоом бөгөөд байгаль шинжлэлийн хичээлээр 1000 орчим туршилт хийж, 6 загвар дээр ажиллах боломжтой.

Giant Road Carpet



Carpets

Автозамыг бодитой дүрсэлсэн ийм хивсэнцэр нь бага насны хүүхдийг замын хөдөлгөөний дүрэм, дохио зэрэгтэй танилцахад тусална.



Geosafari Talking Globe

Fuji уул хаана байдаг вэ? гэх мэт 10000 гаруй асуулт асууж,

түүндээ хариулт өгөх энэ ярьдаг глобус хүүхдийн газарзүйн мэдлэгийг дээшлүүлнэ.

Сургалтын зориулалттай компьютерийн тоглоомуудыг хэрэглэж болно /Educational PC games/

Тоо бодох, уншиж сургах, сэтгэхүй хөгжүүлэх зэрэг ямар нэг зүйлд сургах хөгжилтэй тоглоомууд нь өнгө дүрслэл, үйл явдал сайтай байдаг тул хүүхдийн сурах хүсэл сонирхолыг өдөөж өгдөг.



Arthur's Thinking Games

5-7 насны хүүхдүүдэд зориулсан энэ тоглоом асуудалшийдвэрлэх

чадвар, ой тогтоолт, эрэгцүүлэн бодох чадвар хөгжүүлэх бөгөөд байгаль шинжлэл, газарзүй, түүхийн хичээлээр мэдлэг, чадварыг өсгөдөг.




My first getting ready for school

3-5 насны хүүхдүүдийг сургуульд бэлтгэх энэ тоглоом тоо тоолох, логик сэтгэлгээ, дүрс хэмжээс, ярих сонсох, үсэг таних зэрэг зүйлст сургана.




Become a World Explorer

6-10 насныханд зориулсан энэ тоглоом бүх дэлхийгээр аялаж, газарзүйн мэдлэгээ өсгөхөд тань тусална.



I love science

Шинжилгээ, туршилт хийх замаар шинжлэх ухааны 100 гаруй сэдвийг судлах энэ тоглоом 7-11 насныханд зориулагджээ.



Play & Learn-Reading and Counting

Хүүхдийг уншиж, бичиж сургах 101 тоглоомыг агуулсан, 3-5


насны хүүхдүүдэд зориулсан.



Disney-Princess Fashion Boutique

Энэ тоглоом 4-ээс дээш насны охидуудыг жинхэнэ гүнж болоход нь тусална. Хүүхдүүд

өөрсдийн сайн мэдэх үлгэрийн баатрууд болох Үнсгэлжин, Цасан цагаан, Унтаж буй гоо бүсгүйн аль нэгийг сонгоно. Дараа нь үдэшлэгт оролцох гоо бүсгүйгээ гоёж гангалах ёстой. Энэ тоглоом хүүхдүүдийн гоо сайхны мэдрэмжийг хөгжүүлэх зорилготой.



Miffy's world of colour and shapes

2-5 насны хүүхдүүдэд зориулсан энэ тоглоом хүүхдийг өнгө, дүрс ялгаж сургана.

Сургалт, танин мэдэхүйн интернетийн сайтуудыг ашиглаж болно

Интернетийг хүн

төрөлхтний нэгдсэн аварга том оюун тархи гэж үзэж болохоор болжээ. Энэ нь дэлхийн аль ч өнцөг буланд гарсан шинэ нээлт, ололт зэргээс насан туршдаа суралцах бололцоог олгож байгаа юм. Үүнээс гадна интернетээр мэдээллийн ихэнхийг үнэ төлбөргүйгээр олж авч чадаж байна. Yahoo, Altavista, Google, Excite, mobinet.mn, mol.mn, mongolsearch.com зэрэг хайлтын системүүдийг ашиглан өөрт хэрэгтэй мэдээллийг 3 тэрбум орчим веб хуудаснаас хэдхэн секундын дотор хайж олж болно. Таны хүүхдэд хэрэг болох дэлхийн шилдэг сайтуудыг жагсаавал:

Links 4 kids

Урлаг, зураг, үнэгүй тоглоом, гэрийн даалгавар, математик, багш нар зэрэг талбаруудтай, 18500 гаруй боловсролын веб хуудсуудтай холбоно.

Educational sites

Хүүхдэд зориулсан боловсролын шилдэг сайтуудтай холбоно.

Barking Spiders

Энэ веб хуудас хүүхдэд зориулсан шүлэг, богино

өгүүллэг, түргэн хэллэг зэргийг багтаажээ.

Top 100 preschool sites

Бага насны хүүхдүүдэд зориулсан эх сурвалжууд, шилдэг сайтуудтай холбоно.

Puzzle choice

Бүх насны хүүхдэд зориулсан үгийн сүлжээ, puzzle, тааварт тоглоом зэргийг багтаасан веб хуудас юм.

A to Z kids stuff

Балчир сурагчдад зориулсан хичээлийн төлөвлөгөө, сэдэв, сар тутмын календар зэргийг эндээс үзэж болно.

Top 100 family sites

Гэр бүл, хүүхдийн холбогдолтой эх сурвалжуудтай шилдэг 100 сайттай холбогдоно.

StudyStack

Энэ веб сайтад зочилж ой тогтоолт хөгжүүлэх тоглоомоор тоглож болно.

ABC Kid Genius

Дуу, зураг, видео дүрслэл ашиглаж цагаан толгой, тоо, унших зэрэг зүйлст сургах үнэгүй программууд юм.

Just for kids-fun and free games

Зураг, будаг, puzzle, сургалтын хүүхэлдэйн кино, үнэгүй тоглоом, багш эцэг эхчүүдэд зориулсан эх сурвалжуудыг эндээс олж болно.

Awesome Guitar Lessons for KIDS

Эхлэн суралцагчдад зориулсан гитар тоглож сургах хичээл. Scale, Arpeggios, Mode, Chord, E-theory, Quiz зэрэг сэдвүүдийг хамарсан Flash-н хөдөлгөөнт хичээлүүд байдаг.

ABC Home preschool

Бага насны хүүхдээ гэрээр сургаж, хөгжүүлэх сонирхолтой эцэг эхүүдэд зориулсан эх сурвалжаар баялаг веб хуудас.

Let's Homeschool

Эцэг эх, багш, хүүхэд сурагчдад зориулсан үнэ төлбөргүй сургалтын материалууд, мөн хичээлийн сэдэв бүрээр гэрийн даалгавар гүйцэтгэхэд тусламж материалуудыг энэ веб хуудаснаас олж болно.

Educational - CD's

Энэ веб хуудаснаас боловсрол, сургалтын чиглэлийн CD-ROM, DVD-ROM зэргийг хайж олж болно. Кино, түүх, урлаг, программ хангамж, газрын зураг гэсэн талбаруудаар хайлт хийх боломжтой.

www.discovery.com

Энэ нь Discovery сувгийн веб хуудас бөгөөд байгалийн ухааны мэдээллүүдийг эндээс олж болно. Мөн энэ веб хуудасны Discoveryschool.com талбараас

газарзүй, байгаль шинжлэл, эрүүл мэнд, технологи, дэлхийн түүх хичээлүүдээр багш, сурагчдад хэрэгтэй төрөл бүрийн материал, гарын авлагууд олж авах боломжтой. Discovery компани байгалийн ухааны видео, сурах бичгээрээ алдартай.

www.childrensoftware.com

Хүүхдэд зориулсан программ хангамж үйлдвэрлэгч 600 гаруй компанийн 3,000 гаруй бүтээгдэхүүнээс өөрийн сонирхсоноо хайн олох боломжтой.

www.freelibrary.com

Энэ веб сайтаас дэлхийн сонгодог зохиолчдын намтартай танилцаж, зохиол бүтээлийг нь үнэ төлбөргүйгээр хуулан авч болно.

www.explorescience.com

Байгалийн ухааны сэдвүүдээр мэдээлэл, интерактив туршилт, тоглоом зэргийг багтаасан энэ веб сайт 10-аас дээш насныханд зориулагдсан. Генетикийн удамшлын загварыг судалж, хулгана үржүүлэх, гармоник хэлбэлзэл, виртуал призм ашиглан плазмын физик судлах зэрэг бүтээлч даалгавруудыг гүйцэтгэж болно.

[www.frontiernet /~kidpower/astronomy.html](http://www.frontiernet/~kidpower/astronomy.html)

Хүүхдэд зориулсан астрономийн www.kidpower.com/qcenter.mn

энэ веб сайт нар, нарны систем, галактик, сансар огторгуйн судалгаа зэргийн талаар мэдлэг, өнгөт график, үг зүйн тайлбар толь зэргийг багтаажээ.

www.chem4kids.com

Бага насны хүүхдүүдэд зориулагдсан энэ сайт химийн шинжлэх ухааны тулгуур ойлголтууд болох бодис, атом, химийн элемент, химийн урвал зэрэг зүйлсийн талаар энгийнээр тайлбарласан байдаг.

www.nationalgeographic.com

Энэ сайтаас National Geographic, National Geographic World сэтгүүлүүдийн онлайн хувилбар, газарзүйн хичээлийн гарын авлага, материалууд, хичээлийн төлөвлөгөө, газрын зургууд зэргийг авах боломжтой.

www.geography.about.com

Цаг уур, уур амьсгал, улс үндэстэнүүд, газар хөдлөлт, туг далбаа, цагийн бүс, физик газар зүй, газрын зураг зэрэг газар зүйн шинжлэх ухааны бүхий л сэдвээр арвин баялаг мэдээллийн санг энэ сайтаас олно.

www.physics.about.com

Цахилгаан, соронзон, сонгодог механик, Ньютоны хуулиуд, оптик зэрэг физикийн шинжлэх ухааны бүх л сэдвээр хүссэн

мэдлэгээ энэ сайтаас олж болно. Ер нь About.com сайтаас өөр бусад хичээлээр ч хэрэгтэй мэдээллээ олж болно.

www.oceanicresearch.org/lesson.html

Фото зураг, график, текстэн мэдээлэлтэй энэ веб хуудас далай, далайн амьдралын талаар бүхий л зүйлийг таньд өгүүлнэ.

www.stemnet.nf.ca/~lstringe/art.html

Агуулга, өнгө, сүүдэрлэлт зэрэг урлагийн үндсэн ухагдахуунуудын талаар хүүхдүүдэд ойлгуулах веб хуудас юм.

www.just-for-kids.com

Хүүхдэд зориулагдсан номуудыг нас, сэдвээр нь ангилсан жагсаалттай энэ веб сайтаас сонирхсон номоо хайж олж болно.

Гэрээр суралцахуйн талаар

Хүмүүсийн бодол ...

Karl M. Bunday

Learning in Freedom is growing

Гэрээр суралцах ажил үйл дэлхий даяар эрчимжин хөгжиж, суралцах хамгийн таатай газар сургууль байх албагүй юм гэдгийг бодит туршлага нотлох боллоо. Хүүхдийн хөгжилд эцэг эхийн оролцоо гойд чухал бөгөөд бусад олон мянган хүүхдийн адилаар таны хүүхэд ч сургуульд орохоосоо өмнө гэртээ уншиж сурч чадна.

Гэрээр суралцахуй нь суралцах эрх чөлөөг олгох бөгөөд үүний ачаар бид маргааш яах нь тодорхойгүй өнөөгийн эмх замбараагүй энэ нийгэмд хөл алдахгүй явахад шаардлагатай мэдлэг, чадваруудыг өөрийн сонголтоор эзэмшиж чадна.

Боловсрол судлаачид ирээдүйд сургууль гэж байхаа болихнээ гэж дуугарч, “School is dead” гэсэн гарчигтай номууд ч харагдах болов. Ард түмэн сургуулиас гадуур суралцахуйд суралцаж эхэллээ...

Treva Williams /Ohio State University/

Home schooling

Өнгөрсөн үед хүмүүс гэр нь сургуулиас хол, эсвэл хүүхдээ сургуульд оруулах боломжгүй гэсэн шалтгаанаар гэрээр сургадаг байж. Харин одоо үед чанартай боловсрол, аюулгүй байдал, ач холбогдолыг нь харгалзан үзээд ийм сонголт хийх болов. Профессор Jane Van Galen гэрээр хүүхдээ сургагч эцэг эхүүдийг хоёр төрөлд хуваажээ. Нэгдүгээр төрлийн эцэг эхүүд гэрээ сургууль болгож, улсын сургуулийн стандарт, сурах бичгийг ашигладаг. Харин үзэж судлах хичээлүүдийг чухал, чухал бус гэдгээр нь ялгаатай авч үздэг байна. Хоёр дахь төрөлд хамаарагдах эцэг эхчүүдийн хувьд боловсрол гэдгийг сургуульд заадагаас илүү өргөн хүрээнд авч үзэх бөгөөд үзэж судлах хичээл нь нилээд өргөн сонголттой, нээлттэй байдаг.

Консерватив гэрээр суралцагчдын хувьд хэл зүй, уран зохиол, математик, байгаль шинжлэл, шашин судлал, түүх гэсэн үндсэн 6 сэдвийг сургалтын хөтөлбөртөө

багтаасан байдаг.

Харин либерал гэрээр суралцагчдын хувьд хөтөлбөрт нь юу ч орсон байж болох бөгөөд хүүхдийн сонирхол, авъяас, хувь хүний онцлогийг илүү анхаардаг.

Lauren Brenner-Katz

/хүүхдээ гэрээр сургагч/

Homeschooling Without Reason

Хүүхдээ гэрээр сургаж эхлэх үед намайг галзууруулах шахсан нэг зүйл бол асуулт байлаа. Энэ нь хүүхдийн маань асуултууд биш, харин найз нөхөд, хамаатан садан, хөршүүдийн маань тавьсан асуултууд юм. Тэд “Чи өдөрт хэр олон цагаар хүүхэдтэйгээ байж чадах хүн бэ?” “Хүүхдээ хэрхэн үгийг чинь сонсдог болгох юм”, “Чи үүнийг чадах юм уу?” гээд л янз бүрийн асуултыг надад тавина. Тавьсан асуулт бүрд оновчтой хариулт надад олдохгүй байсан нь намайг энэ ажил үйлсдээ эргэлзэх байдалд оруулдаг байлаа. Гэвч удалгүй би эдгээр асуултуудад өгөх оновчтой хариултыг олсон. “Мэдэхгүй, гэхдээ учир нь олдох байхаа” гэж хариулдаг болов. Гэрээр хүүхдээ сургах нь зөв сонголт гэдэгт би огт эргэлзэхгүй байна. Сонголт маань зөв юм

чинь бэрхшээлийг давах арга
чарга олдож л таарна... ы

Susannah Harris

Unschooling-Learning through everyday life

Хүүхэд сургууль дээрээ гэхээсээ илүү гэртээ илүү сайн сурдаг. Гэрээр суралцагч хүүхэд аль ч хичээлээр амжилтанд хүрч, сайн суралцаж чадна. Энэ нь сурах арга барил, хугацаагаа өөрийн дураар сонгож болдогтой холбоотой. Гэрээр хүүхдээ сургагч эцэг эхүүд хүүхдүүд нэг ижил зүйлийг өөр өөр арга замаар сурч, мэдэж чаддаг болохыг ойлгодог ...

Candace Thayer Coe

An Unschooler's Approach

Бид Канад гаралтай Америкчууд. Одоо Филиппинд амьдарч байна. Манайх ам бүл 4. Том хүү Chris 14, бага хүү Amber 12 настай. Нөхөр маань Азийн хөгжлийн банкинд ажилладаг. Энд ирээд хэл, соёлын ялгаатай байдлаас улбаалан хоёр хүүхдээ гэрээр сургаж байна. Филиппинд хүүхдээ гэрээр сургагч эцэг эхүүд нилээд цөөн байдаг бололтой.

*Lara Kehler/гэрээр хүүхдээ
сургагч/*

Homeschooling is challenging

Би хувьдаа хүүхдээ гэрээр сургаж, өсөлт хөгжилд нь анхаарах нь эх хүний хүлээх ёстой эрхэм үүрэг гэж боддог. Хүүхдүүд маань гэртээ байх дуртай. Би ч гэсэн тэдэнтэйгээ аль болох олон цагаар хамт байх дуртай. “Гэртээ өдөржин хүүхдүүдтэйгээ өнжих нь залхуутай биш үү?” гэж найз нөхөд минь асуух нь бий. Залхуутай нь үнэн. Гэвч зүрх сэтгэл маань намайг ингэ гэж шаарддаг юм гэж би хариулдаг. Та ч гэсэн зүрх сэтгэлийн дуудлагаа дагавал үр хүүхэд, гэр бүлийнхээ төлөө үүнийг хийж чадна.

Jim&Susan Stephenson

A Homeschool story

Бид сурч, боловсрох ажил үйл хөгжилтэй, сонирхолтой байх ёстой гэдэгт итгэдэг. Хэрэв сурч байгаа зүйл нь сонирхол татахгүй, уйтгартай бол хүүхэд сурч боловсрохын чухлыг мэдэрч ойлгож чадахгүй.

Хүү Майкл маань гэрээр сурч боловрсон юм. Хүү

маань Michael Olaf Montessori -н катологийг ашиглан бидний олж ирсэн номуудыг уншиж, сургалтын хэрэгслүүдийг оролдсоор өдрийг өнгөрөөдөг байлаа. Бид хүүгээ ямар ч хугацаагаар, өдөр, шөнө, амралтын ямар ч өдөр өөрийн сонгосон арга барилаар, өөрийн хүссэн зүйлээ судлахыг нь зөвшөөрдөг байсан. Харин бидний гол үүрэг бол хүүхдийнхээ сонирхсон бүх сэдвээр хэрэгтэй гэсэн бүх хэрэгслийг олж өгөх явдал байлаа. Эцэг, эх нь болсон бид хоёр өдөржин завгүй тул Майклдаа цаг бага зарцуулдаг байсан. Бага сургуульд байхад нь математик, англи хэлний хичээлд нь туслах 2-3 цагийг 7 хоногт гаргаж чаддаг байв. Гэрт маань зурагт, видео тоглоом, компьютер тоглоом огт байгаагүй. Энэ бүх байдал хүүг маань гэртээ, бие даан бүтээлчээр суралцахад нөлөөлсөн. Үүний ачаар хүү маань сургууль төгсөлтийн шалгалтаа амжилттай өгч, 600 оноо авсан юм.

Багш нарын өгөх зөвлөгөө

Montessori Homeschooling
төвийн багш нар

3-6 насны хүүхдийг гэрээр сургахад юуг анхаарах вэ?

Гэртээ аливаа зүйлийг хүүхдийн нүдээр олж харахыг хичээ. Хүүхдэд аливаа зүйлд оролцох, хүнд хэрэгтэй байх мэдрэмж хэрэгтэй байдаг. Өдөр тутмын амьдралын үйл ажилд оролцох замаар үүнийгээ тэд олж авдаг. Бага насны хүүхэд “Үүнийг өөрөө хийх боломж олгооч” гэсэн хүсэл эрмэлзлэлээр дүүрэн байдаг. Хоол бэлдэх, цэвэрлэгээ хийх, цэцэрлэгээ янзлах, гутлаа тослох, тоглоомоо эмхлэх зэрэг ажилд оролцох бололцоог та хүүхэддээ олгож чадах уу? Хүүхдийг бие даах боломжоор хангаж өгвөл өөртөө итгэх итгэлийг түүнд өгч чадна. Гэр орон чинь урлаг, соёл, шинжлэх ухааны үйлд зориулагдсан байх ёстой. Энд компьютер тоглоом, зурагт, амттаны аль нь ч байх ёсгүй. Харин сайтар бодож сонгосон чанартай ном, тоглоом, сургалтын хэрэгсэлүүд л байх ёстой. Хүүхдийг аливаа нэг зүйлийг сурах, хийхэд албадаж

болохгүй. Хүүхдээ сайн ажиглаж, сонирхолынх нь дагуу хийлгэж, хувь хүнийх нь онцлогт тохируулан сургах нь зөв.

6-18 насныханы хувьд юуг анхаарах вэ?

1. Хүүхэд цаг үргэлж орчноосоо, хүмүүсээс суралцаж байдаг. Иймээс суралцах таатай орчин, нөхцлийг бий болгож өгөх хэрэгтэй.
2. Хүүхэд сонирхлыг нь татсан, дуртай зүйлээ илүү сайн сурдаг. Хүчээр, бусдын эрхэнд сурсан зүйл нь хоногшин үлдэхдээ муу байдаг.
3. Яагаад энэ зүйлийг сурч мэдэх ёстой вэ? гэдгийг хүүхдэд сайтар ойлгуулах ёстой.
4. Хүүхдийг тогтсон хуваарийн дагуу суралцахад нь тусалж, суралцах арга барилыг нь хөгжүүлж, товлосон хугацаанд хариуцлагатай хандаж сургах ёстой. Гэхдээ ийм ажил үйлд өдөрт 2-3 цагаас илүү хугацаа зарцуулах хэрэггүй.
5. Хүүхдийнхээ хүсэл сонирхлыг дага. Хүүхдийн сонголт, шаардлагыг хүндэтгэж, дэмжвэл хүүхэд үр дүнтэй суралцаж, эцэг эхээ баярлуулж чадна.

Gordon Dryden

Суралцах чадвар

Гэрээр суралцагчдын хувьд бие даан суралцах чадвараа хөгжүүлэх явдал онцгой чухал байдаг. Энэ их өөрчлөлтийн эрин үед бид юуг мэдэж авсан бэ? гэдгээрээ биш харин суралцахуйд хэрхэн суралцсан бэ? гэдгээрээ тодорхойлогдох болжээ. Хэрхэн суралцах ёстойд суралцах нь амжилтанд хүрэх арга замыг нээж, илүү ихийг сурч авахад тусална. Та өөрийн суралцах арга барилдаа анхаарал хандуулвал ямар арга техникээр би илүү үр дүнд хүрч болох, өнгөрсөн хугацаанд суралцахуйн ямар арга барил намайг амжилтанд хүргэж байв гэдгийг олж тогтооно.

Сайн суралцахад дан ганц ухаантай байх нь хангалттай биш, харин суралцах хүсэл эрмэлзэлээр дүүрэн байх нь чухал. Суралцахуйд чиглэсэн сэдлийг олох эсэх нь суралцъя гэсэн хүсэл эрмэлзэл рүү биднийг чиглүүлэх, эсвэл тэр замаас хазайлгах хүчин зүйл болох юм.

Суралцах чадвар хамгийн өндөртэй хүмүүс тамирчид юм.

Бидэнд тамирчдаас суралцах

зүйл их байна.

1. Бүх тамирчдад хүсэл мөрөөдөл байдаг. Тэд зорилгодоо хүрэхийн тулд боломжгүйг ч гэсэн мөрөөдөж чаддаг

2. Тамирчин бүрд тодорхой зорилго байх бөгөөд түүнд хүрэх замаа дэс дараалсан алхамуудад хуваасан байдаг

3. Шилдэг тамирчид өөрийн бие, хөдөлмөр, ухааныг нэгэн зэрэг ашигладаг

4. Тамирчид чухам юунд хүрэхийг хүсч байгаагаа тодорхой дүрсэлж, өөрийн зорилгыг тодоор олж харахад суралцсан байдаг

5. Тамирчин бүр ялчих юмсан гэсэн бодол санаагаар дүүрэн байдаг.

6. Тамирчин бүрт дасгалжуулагч, чиглүүлэгч, зөвлөх байдаг

7. Шилдэг тамирчид алдаанаасаа суралцаж сурсан байдаг. Тэд алдааг сургамж, хичээл хэмээн хүлээн авдаг.

8. Аваргууд зорилгодоо хүрдэг

Олимпийн таван төрөлтийн аварга Мэрилин Кинг өөрийн амжилтанд хүрсэн томъёог дараах байдлаар томъёолжээ:

Амжилт = Сонирхол + алсын хараа + оролдлого

Чамд сонирхол, алсын хараа байвч оролдлого байхгүй бол чи ердөө л нэг хоосон мөрөөдөгч гэсэн үг. Чамд алсын хараа, оролдлого байвч сонирхол байхгүй бол чи ердөө л нэг тааруухан амьтан. Чамд сонирхол, оролдлого байвч алсын зөв хараа байхгүй бол чи зорилгодоо хүрнэ, гэвч тэр чинь алдаатай байх болно.

Glenn Doman

Хүүхдийг уншиж сургах

Ямар ч эцэг эх хүүхдээ гэрээр уншиж сургаж чадна. Уншиж сургах дараах алхамуудыг би танд санал болгоё.

Уншиж сургах эхний алхам:

Хүүхдийг төрсөн цагаас нь л тод зурагтай номтой танилцуулж, өдөр болгон уншиж өгч бай.

Уншиж сургах хоёр дахь алхам:

Хүүхдийн унших, бичих үйл ажиллагааг түүний 5 мэдрэхүйтэй холбож өгөх хэрэгтэй. Өөрийн барьж үзсэн, амтыг нь мэдэх, сонсож үзсэн зүйлийг хүүхэд илүү сайн мэдэрч ойлгон, сайн уншиж сурдаг. Жишээ нь, “алим” гэж уншуулах

гэж байгаа бол алим гэсэн үгийн ард алимны гоё зураг байх ёстой. **Уншиж сургах гурав дахь алхам:**

Хүүхэд юу харж байгааг нь бич. Жишээ нь: хамар, хуруу, гутал, нүд, таваг

Уншиж сургах дөрөв дэх алхам:

Хүүхэд юу хийж байгааг нь тодорхойлж өг. Жишээ нь явах, суух, гүйх, бүжиглэх, ярих, чимээгүй, удаан гэх мэтээр. Ер нь уншуулж сургах үйл ажиллагаа нь амьдралд ойрхон, хүүхдийг хөгжөөсөн, баяр баясгалан өгсөн ажил үйл байх ёстой.

Gordon Dryder, Coline Rose
Чөлөөтэй бичиж сургах
24 алхам

Английн эдгээр сурган хүмүүжүүлэгч нар хүүхдийг чөлөөтэй бичиж сургах дараах алхамуудыг санал болгодог:

1. Хүүхдийг мөлхөж эхлэх үеэс нь хийн бөмбөлөгөөр тоглуул
2. 9-18 сартайд нь хуванцар аяга, бөмбөг нэг саванд хураан эмхлэх дасгал хийлгэ
3. 12-18 сартайд нь янз бүрийн зүйл өлгөх боломжтой самбар хийж өг
4. 18-24 сартайд нь том хэмжээтэй, ухаан шаардах

тоглоомоор тоглуул

5. 18-24 сартайд нь сувд, шүр хэлхүүлж тоглуул
6. 2 настайгаас нь гараараа эмхлэн зохион байгуулах арай илүү ухаан сорьсон тоглоомоор тоглуул
7. Будааг нэг савнаас нөгөө сав руу юүлэх дасгал хийлгэ. Дараа нь будаагаа усаар соль
8. Хамгийн энгийн муруй сарий үсэг бичүүл
9. Усаар байнга тоглуул
10. Гараар, хуруугаар, уруулаар зураг зуруул
11. Тоглох бөмбөгийг нь томруул
12. Жижиг бичгийн самбар авч өгч зуруулж бичүүл
13. 2-3 нас хүртэл нь хөндий гоймон татаж сунгах
14. 30 сартайгаас нь цаасан салфетка хураалгах
15. 3 настайгаас ухаан ихээр сорьсон том хэмжээний бодлого бодуулах
16. 3 настайгаас нь цэвэр бичлэгийн том дэвтэр дээр зуруулах
17. Цэвэр бичлэгийн арай жижиг дэвтэр ашиглах
18. Хуруугаараа үсгийн хэлбэрийг тойруулан зурах
19. 3-аас 5 нас хүртлээ гутлаа цэвэрлэж сурах

20. 4 нас хүртлээ өөрийн нэрийн бичлэгийг хуулбарлан зурах
21. Та хүүхдийнхээ анхны зохион бичлэгийг бичнэ. Хүүхэд чинь түүнийг давхарлан /тойруулан/ бичнэ.
22. Худалдан авах зүйлсийнхээ жагсаалт хийхэд хүүхэддээ тусал.
23. Бичгийн чадварыг хөгжүүлэх компьютерийн тоглоом
24. 5 нас хүрэхдээ хүүхэд идэвхтэй бичиж сурна

ESL сургалтын төвийн захирал Н.Эрдэнэ-Өрнөх

Эцэг эхчүүдэд өгөх зөвлөгөө

Өнөөдөр дэлхий нийтийн мэдээлэл харилцааны үндсэн хэл англи хэл болоод байна. Монголчууд бид ч гэсэн англи хэлийг нилээд өндөр ач холбогдол өгч судлах боллоо. Гэвч англи хэлний сургалт санаанд хүрэхээргүй байсаар өнөөг хүрлээ. Үүний учир юу вэ?

Англи хэлийг заах үндсэн хоёр хандлага байдаг. Нэг нь EFL /English as a foreign language/ буюу англи хэлийг гадаад хэл хэмээн судлах. Хоёр дахь нь ESL /English as a second language/ буюу англи хэлийг хоёр дахь хэлээ гэж үзэн судлах юм.

Англи хэлийг гадаад хэл

/EFL/ хэмээн судлагчид өдөрт англи хэлний цөөн цагийн хичээлд суух бөгөөд хичээлийн дараа өөрийн төрөлх хэлээр бусадтай харилцаж, бусад хичээлээ төрөлх хэл дээрх сурах бичгээр судалж, төрөлх хэлээрээ ихэнх мэдээллийг хүлээн авдаг.

Англи хэлийг хоёр дахь хэлээн /ESL/ хэмээн судлагчид өглөө төрөлх хэл дээрээ бусад төрлийн хичээлийг судалж болох боловч гэртээ хариад англи ном, англи эх сурвалж ашиглаж хичээлээ хийх ба эцэг эх, бусад хүмүүстэй англи ба төрөлх хэлээрээ ярьж, мэдээллийг англи ба төрөлх хэлнийхээ аль алинаар энэ тэнцүү хүлээн авдаг. Үүнээс улбаалаад англи хэлийг ESL хэмээн судлагчид англи хэлийг илүү сайн, төрөлх хэл шигээ эзэмшиж чаддаг байна.

Гэрээр суралцагчид англи хэлийг ESL арга барилаар сурах боломжтой. Хүүхэддээ багаас нь англи хэл өөрсдөө заасан эцэг эхүүд өөрсдөө ч англи хэлтэй болох бөгөөд хүүхэддээ англи хэлийг төрөлх хэл шигээ эзэмших боломжийг нээж өгдөг.